

## ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2015 оны 04 дүгээр  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит хурал товлосон ёсоор 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:12 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-18 хаяганд байрлах тус компанийн МА-III байрны хурлын зааланд эхлэв. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн хурлаас гаргасан шийдвэрийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Лутаагийн Буянбат хурлыг даргалав.

Хурлын дарга Л.Буянбат Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит хуралд тус компанийн саналын эрхтэй 1,189,983 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 623 хувьцаа эзэмшигчид оролцохоос саналын эрх бүхий 1,018,849 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 21 хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирснийг мэдэгдэж хурлын ирц 85.6 хувь болсоныг танилцуулав. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасны дагуу хурлын ирц хүчин төгөлдөр болсон тул Л.Буянбат хурлыг нээж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн хурлаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулахаар товлож, хурлаар хэлэлцэх асуудлыг баталж, хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссын даргаар Л.Буянбат, гишүүдээр Л.Энхнасан, Ш.Мөнх-Очир нарыг, хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Л.Буянбатыг, Тооллогын комиссын даргаар Э.Чулуунтогтох, гишүүдээр Н.Гомбосүрэн, П.Сансартуяа нарыг томилсныг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэг, дотоод журмыг танилцуулж батлуулав.

Хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэв. Үүнд:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах зэрэг болно.

Хурлын дараалал, дотоод дэгийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Л.Буянбат "Компанийн 2014 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт", Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Ш.Мөнх-Очир "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай", "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийн тухай" зэрэг хурлаар хэлэлцэх асуудлыг дэлгэрэнгүй танилцуулж илтгэв. Л.Буянбат хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулж дууссан тул дэгийн дагуу асуулт асууж, хариулт явуулахыг мэдэгдэв.

Ж.Чимэдцэрэн: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаар компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг авч хэлэлцсэн. Энэхүү тайлангийн талаарх дүгнэлтэд өгөх саналыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс авсан бөгөөд нэр бүхий гишүүдээс хүргүүлсэн санал хүсэлтийг тусгаагүй байна. Дүгнэлтэд Компанийн хуулийн 96.4.2-т заасны дагуу тайлангийн хугацаанд компанийн эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин, урамшууллын хэмжээг тодорхой тусгаагүй байна. 2014 онд компанийн ажиллагсдын дундаж цалин 500,000 төгрөг байсан бөгөөд компанийн эрх бүхий албан тушаалтны авсан цалин, урамшуулал нь их зөрүүтэй байна. Мөн 2014 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн ажиллагсдын цалинг нэмэгдүүлэх талаар санал гарч байсан. Иймд дараах мэдээллийг өгөхийг хүсч байна. Нэгд, 2014 онд компанийн эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин, шагнал урамшууллын хэмжээг, хоёрдугаарт, компанийн 2014 онд хийсэн хөрөнгө оруулалттай холбоотой мэдээллийг хэлнэ үү.



Л.Буянбат: Таны ирүүлсэн санал, хүсэлтийн дагуу компанийн цалин, урамшууллын системийг сайжруулах талаар дүгнэлтэд тусгагдсан байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдэд олгох цалин, урамшууллын хэмжээг компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэж баталдаг бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн 2014 онд авсан цалин, урамшууллын хэмжээг уншиж танилцуулав.

Л.Энхнасан: Компанийн 2014 онд олгосон цалин, урамшууллын хэмжээний талаар тодорхой мэдээллийг хүснэгтээр гаргаж өгсөн. 2014 онд Ньютел компанитай байгуулсан урт хугацааны түрээсийн гэрээ дуусгавар болж, шинээр түрээслэгч байгууллагуудтай гэрээ хийх, сонгон шалгаруулах зэрэг шалтгааны улмаас компанийн орлого тодорхой бус байсан тул 2014 онд ажиллагсдын цалинг нэмэгдүүлэгүй. Гэхдээ 2014 онд ажиллагсдын сарын дундаж цалин, урамшуулал 800,000 мянган төгрөгний хэмжээнд байсан. Харин Мобиком, Ньютел пропери, Скайтел компанитай шинээр түрээсийн гэрээг байгуулснаар 2014 оны сүүлээр компанийн үйл ажиллагаа жигдэрч, орлогын тогтвортой эх үүсвэр хангагдсан тул 2015 оны 01 дүгээр сарын 01-нээс компанийн ажиллагсдын цалинг 2 дахин нэмэгдүүлсэн. Одоогоор ажиллагсдын сарын дундаж цалин 1,216,000 төгрөг болсон бөгөөд компанийн эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээг уншиж танилцуулав. Компанийн 2014 онд хийсэн хөрөнгө оруулалтын дүнг дэлгэрэнгүй танилцуулж, нийт дүнгээр МА-I барилгын засвар, хөрөнгө оруулалт нь 207,409,385 төгрөг, МА-III барилгын засвар, хөрөнгө оруулалт нь 434,409,385 төгрөг болсоныг мэдэгдэв.

С.Мягмарсүрэн: Намайг Мягмарсүрэн гэдэг бөгөөд тус компанийн хувьцаа эзэмшигч, мөн Ард Капитал (БДК) компанийг төлөөлж хуралд оролцож байна. Компанийн тайлан болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг сонсоод компанийн удирдлагыг 2014 онд сайн ажилласан гэж дүгнэж байна. Хоёр асуулт байна. Нэгдүгээрт, компанийн сарын нийт орлого хэд болсон бэ. Компани нь санхүүгийн модель боловсруулж ажиллах уу. Хоёрдугаарт, Цаашид ерөнхий болон удирдлагын зардлыг бууруулж ажиллах боломжтой юу.

Л.Энхнасан: Ньютел (XX) компанитай байгуулсан удаан хугацааны түрээсийн гэрээ 2014 оны 07 дугаар сард дуусгавар болсон. Одоогийн байдлаар Мобиком, Ньютел, Скайтел (XX) компанитай түрээсийн гэрээг 3 жилийн хугацаатайгаар байгуулан ажиллаж байна. Түрээсийн сарын нийт орлого 243,295,934 төгрөг болсон. Компани санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, өөрийн санхүүгийн моделийг бий болгож ажиллахад анхаарлаа хандуулж байна. Ерөнхий болон удирдлагын зардал 2014 онд их гарсан байгаа. Энэ нь түрээсийн гэрээг шинэчлэн хийхтэй холбогдсон зах зээл, маркетингийн судалгааны зардал, МА-I болон МА-III барилгын засвар үйлчилгээний зардал, мэргэжлийн байгууллагын болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний гэх мэт зардал их гарсантай холбоотой юм. Мөн хүлээн авалтын зардал гүйцэтгэлээр 19,693,800 төгрөг гарсан бөгөөд үүнд тус компанид ажиллаж байсан 300 гаруй ахмадуудыг хүлээн авах, хөнгөн аж үйлдвэр байгуулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан компанийн удирдлагад ажиллаж байсан 30 гаруй хүнийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх, өндөр настан ахмадуудад буцалтгүй тусламж тэтгэмж өгсөн зэрэг зардал багтаж байгаа. Дээр дурдсан зардлуудыг 2015 онд хэмнэх боломжтой бөгөөд МА-II барилга (ТЕДИ төв)-ийн дээврийн засвар, мөн барилгын иж бүрэн дулааны болон сантехникийн засварыг хийхээр төлөвлөөд байна.

Л.Буянбат: Компанийн ерөнхий ба удирдлагын зардлыг бууруулахын зэрэгцээ компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх, үндсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, тэдгээрийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагаар дамжуулан тодорхой ажлуудыг төлөвлөөд явж байгаа.

Г.Оюунгэрэл: Компанийн ерөнхий болон удирдлагын зардлыг бууруулж ажиллах саналыг дэмжиж байна. Тайланд бусдаар хийж гүйцэтгүүлсэн зардал болон маркетингийн зардал, магний үйлдвэрлэлийн төслийн зардал гэж дурдагдсан. Эдгээр зардлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү. Мөн магний үйлдвэрлэлийн төслийн талаар мэдээлэл өгөхийг хүсэж байна.

Л.Энхнасан: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ болон зах зээл, маркетингийн судалгааны зардалд дараах зардал багтаж байна. Үүнд: компанийн хэтийн төлөв, барилгын эскиз зургийг хийлгэхэд Аркетайп компанид- 36,363,600 төг, зөвлөх үйлчилгээний хөлсөнд Хорайзон компанид- 20,581,900 төг, МА-III барилгын дотоод заслын зураг төсөв хийлгэхэд Арчис компанид- 8,181,800 төг, инженерийн шугам сүлжээний дэвсгэр зураг хийлгэхэд М

Эйч И компанид– 3,914,300 төг, үнэлгээний ажлын хөлсөнд Далай Ван аудитын компанид– 1,813,600 төг, лицензийн төлбөр Интерактив компанид– 1,201,000 төг, нийт дүн 72,361,200 төгрөгийн ажил үйлчилгээний зардал гарсан байна. Мөн судалгааны ажлын зардалд 30,071,500 төгрөгийн зардал гарсан бөгөөд үүнд түрээсийн гэрээг шинэчлэхтэй холбоотой зах зээлийн судалгааны ажилд ЭнСиЭс компанид– 18,071,500 төгрөг, маркетинг зах зээлийн судалгаа хийлгэхэд Даяар зөвлөх компанид– 12,000,000 төгрөгийг зарцуулсан байна.

Л.Буянбат: Магний үйлдвэрлэлийн төслийг Япон улсын ИНАБАТА компанитай олон улсын хэмжээнд мөрдөгддөг нууцлалын гэрээг байгуулан хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Одоогийн байдлаар гадаадын түнштэй яриа хэлэлцээний шатанд явж байгаа бөгөөд техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, зах зээлийн судалгаа, эдийн засгийн үр ашгийн тооцоог хийх зэрэг ажлуудыг хийж эхлээд байна. Энэхүү төслийн хүрээнд 2014 онд тус компанитай бизнесийн уулзалт, яриа хэлэлцээ хийх зорилгоор Япон улсад, мөн зах зээлийн судалгаа хийх зорилгоор Кени улсад зорчих зэрэг гадаад томилолтын зардал гарсан бөгөөд дотоодын зах зээлийн судалгаа хийх, дээрх компанийн зочид төлөөлөгчдийг хүлээн авах зэрэг дотоод томилолтын зардлын хамт нийт 46,878,600 төгрөгийн зардал гарсан. Уг төсөл нь бизнесийн цар хүрээ, хэмжээний хувьд нилээд том төсөлд тооцогдох бөгөөд ойрын 5 жилд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Ж.Чимэдцэрэн: Магний үйлдвэрлэх төслийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан уу.

Л.Буянбат: Энэхүү төслийг 2014 оны эхээр Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргасан. Төслийн хэрэгжилтийн талаар уг хурлаар шинээр сонгогдох Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж хэлэлцүүлнэ.

Ч.Батбилэг: Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаас компанийн эдийн засгийн үзүүлэлтүүд дээшилсэн, үйл ажиллагаа нь жигдэрсэн байгаа бөгөөд орлогын тогтвортой эх үүсвэрийг хангаж ажиллахад компанийн удирдлага 2014 онд сайн ажилласан байна. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн урамшууллын хэмжээг компанийн жилийн орлогын 2,0 хувь гэсэн байна. Энэ шагнал урамшуулал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд олгох урамшуулал юм уу компанийн нийт ажиллагсдад олгох урамшууллын хэмжээ юм уу. Хэрвээ энэхүү урамшуулал нь зөвхөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд хамаарагдаж байгаа бол компанийн ажиллагсдын шагнал урамшуулал ямар хэмжээгээр, хэлбэрээр олгогдох вэ. Компанийн Ахмадын зөвлөлийн даргын хувьд асуулт байна. Компаниас гаргасан журмын дагуу өндөр настан, ахмадуудыг хоёр жилд 1 удаа хүлээж авна гэсэн байгаа. Компанийн ашиг, орлого нэмэгдэж байгаа учраас ахмадуудыг жилд 1 удаа хүлээн авч хүндэтгэл үзүүлж болох уу. Энэ талаар олон ахмад санал хүсэлтээ гаргаж уламжилж өгөхийг хүсдэг. Компанийн 2015 оны төлөвлөгөөнд энэ асуудлыг тусгаж Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулж өгөхийг хүсье.

Л.Буянбат: Компанийн жилийн орлогын 2,0 хувьтай тэнцэх урамшуулал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргад олгогдох бөгөөд энэхүү шагнал урамшууллын хэмжээг компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэж батална. Компанийн 2014 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж баталсны дагуу энэ жилд олгох урамшууллын хэмжээ нь компанийн 2014 оны жилийн орлогын 2,5 хувьтай тэнцэж байгаа. 2015 онд компанийн ашиг орлого нэмэгдэж байгаатай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллын хэмжээг компанийн жилийн орлогын 2,0 хувь болгож, хурлаар батлуулах санал оруулж байна.

Л.Энхнасан: Компанийн ажиллагсдын цалинг 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс нэмсэн бөгөөд ажиллагсдад шагнал урамшуулал олгох шинэчилсэн журам боловсруулж, мөрдөж ажиллаж байна. Энэхүү журмын дагуу ажлын цагийн ашиглалт, ажлын үр дүнгээс хамааран тухайн албаны даргын тодорхойлолт, үнэлэлт дүгнэлтээр компанийн ажиллагсдад улирал тутам тэдгээрийн 3 сарын цалингийн дунджаас 40 хувьтай тэнцэх хэмжээний шагнал урамшуулал олгоно. Ахмадуудыг жилд нэг удаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэх тухай асуудлыг 2015 оны төлөвлөгөөнд тусгаж шинээр сонгогдох Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулж зардал төсвийг батлуулна. Компанийн МА-III байр (Анкор төв)-ыг засвар хийж тохижуулан үйл ажиллагааг нь эхлүүлсэн тул энэ жилээс өөрийн байрандаа ахмадуудыг хүлээн авах боломжтой болсон.

К.Алия: Би Таван Богд (БДК) компанид захирлаар ажилладаг бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн удирдамжийн дагуу Компанийн засаглалын үндэсний төвийг төлөөлж энэ хуралд оролцож байна. Хурлаар хэлэлцүүлж буй тайлан илтгэлүүдийг сонслоо. Үүнтэй холбогдуулан хоёр асуулт байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан уу. Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд уг хуралд оролцож байна уу. Компанийн засаглалын кодексийг танай компани дээр хэрэгжүүлж байгаа юу.

Л.Буянбат: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанийн засаглалын сургалтад 100 хувь хамрагдаж гэрчилгээ авсан. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд Төлөөлөн удирдах зөвлөлийн 7 гишүүн оролцож байгаа бөгөөд үүний дотор Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн С.Итгэл оролцож байна. Компанийн засаглалын кодексийг өөрийн компанид хэрэгжүүлэн ажиллахад анхаарлаа хандуулан ажиллаж байгаа бөгөөд Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж (ХК) компаниас гаргасан холбогдох дүрэм журам, заавар, компанийн засаглалын кодекс, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо хадгаламжийн болон бусад байгууллагуудтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж ажилласнаар Монголын Хөрөнгийн биржэд бүртгэлтэй 237 компаниас 4 байранд шалгарч зохих шалгуур, үзүүлэлтийг хангалттай биелүүлдэг компанийн нэг болсон. Мөн Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж, Компанийн засаглалын үндэсний төвөөс зохион байгуулагддаг төрөл бүрийн хурал, уулзалт семинар, сургалтад тогтмол хамрагдаж ирсэн.

Ж.Байгалмаа: Миний бие компанийн хувьцаа эзэмшигч Ж.Банзрагчийн итгэмжлэлээр хуралд оролцож байна. Хуралд тавьсан тайлан илтгэлүүдийг сонсож танилцлаа. Тайлангийн хугацаанд компанийн ашиг орлого нэмэгдэж, сайн ажилласан байна гэж дүгнэж байна. Түрээсийн гэрээг шинээр байгуулж, үүрэн телефоны томоохон оператор болох Мобиком, Скайтел зэрэг өрсөлдөгч компаниудыг оруулсан нь хэр зохистой вэ. Скайтел компанийн түрээсээр эзэмшиж буй МА-I барилга болон Мобиком компанийн түрээсээр эзэмшиж буй МА-II барилга (ТЕДИ төв)-ыг холбосон 2 давхарын хананд "Берлиний ханыг нураа" гэсэн бичээс байна. Хоёр өрсөлдөгч компанийг нэг дор оруулснаар түрээслэгчид, хэрэглэгчдийн эрх ашиг хохирч байна гэж үзэж байна уу. Энэ талаар цаашид ямар арга хэмжээ авч ажиллах вэ.

Л.Энхнасан: Та бүхний мэдэж байгаагаар 2014 оны 7 сар хүртэл Нютел компани урт хугацааны түрээсийн гэрээний дагуу байр талбайг түрээсэлж байсан болохоор дээр дурдсан зөрчил гардаггүй байсан. Харин 2014 оны сүүлийн хагас жилд МА-I барилгын 1, 2 давхарыг Скайтел компани түрээсэлдэг болсноор хоёр өрсөлдөгч компанийн хооронд уг зөрчлүүд гарч байна. Эдгээр хоёр компанитай байгуулсан түрээсийн үйлчилгээний гэрээнд түрээслэгчид, хэрэглэгчдийн эрх ашгийн үүднээс барилгын хоорондох орох гарах гарцыг чөлөөтэй байлгах талаар холбогдох заалт орсон байгаа. Гэхдээ бизнесийн өрсөлдөгч хоёр байгууллагын хоорондох харилцааны асуудал, зах зээлийн өрсөлдөөний нөхцөл байдал нөлөөлж байгаа болохоор бид хөндлөнгөөс оролцох боломжгүй юм. Гэхдээ уг ханыг нээх, орох гарах гарцыг нээлттэй байлгах нөхцлийг бүрдүүлэх талаар бодлого баримталж ажиллаж байна.

Ж.Чимэдцэрэн: Хурлаар хэлэлцэж буй асуудлаар тодорхой мэдээ мэдээллийг авлаа. Компанийн 2014 оны үйл ажиллагааны талаар саналаа хэлэхэд компанийн эдийн засгийн үзүүлэлтүүд дээшилсэн, ашиг орлого нь нэмэгдсэн, үйл ажиллагаа нь сайжирсан, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлсэн гэж үзэж компанийн удирдлага хангалттай сайн ажилласан байна гэж дүгнэж байна. Цаашид компанийн удирдлагад үйл ажиллагаандаа дараах зүйлийг анхаарч ажиллахыг зөвлөмөөр байна. Үүнд: Компани нь зардлаа хэмнэх бодлогыг тууштай баримтлах, компанийн ажиллагсдын цалин, урамшууллын бодлогоо шинэчилж, мөрдөж ажиллах шаардлагатай байна. Миний бие Тахько (ХК) компанийн нийт хувьцаанаас 272,77 ширхэг хувьцааг хасаж, компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах асуудлаар санал шаардлага гаргаж 2015 оны 02 дугаар сарын 05-нд компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулсан. Уг хурлын шийдвэр нь Компанийн хуулийн 63.7 дугаар заалтыг зөрчсөн гэж үзэж байгаа тул холбогдох хуулийн байгуулагад хандаж гомдлоо шүүхэд гаргасан болохыг мэдэгдэж байна. Ингээд хувьцаа эзэмшигчдээс гарсан санал, хүсэлтийг хурлын тэмдэглэлд оруулж компанийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг санал болгож байна.

Л.Буянбат: Өөр санал хүсэлт, асуулт асуух хүн байхгүй бол хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчид өнөөдрийн хурлаар хэлэлцсэн асуудлаар саналын хуудсаар саналаа өгнө үү. Тооллогын комисс саналын хуудсыг тарааж, санал өгөх журмыг танилцуулав.

Саналын хуудсаар санал хураалт явуулж, тооллогын дүнг гартал хурал завсарлав. Завсарлага 11:45-13.20 цаг хүртэл үргэлжлэв.

Л.Буянбат: Тооллогын комисс тооллогын дүнг гаргаж дууссан байна. Тооллогын дүнг танилцуулахыг мэдэгдэв.

Э.Чулуунтогтох: Тооллогын комисс тооллогын дүнг гаргалаа. Нийт 23 ширхэг саналын хуудас хүлээн авч, үүнээс 19 ширхэг саналын хуудсыг хүчинтэй, 4 ширхэг саналын хуудсыг хүчин төгөлдөр бус гэж үзсэн болохыг танилцуулаад Тооллогын комиссын дүнгийн тухай 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Л.Буянбат: Тооллогын комиссын тооллогын дүн, шийдвэрийг батлах тухай болон компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг зөвшөөрөх тухай, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлыг батлах тухай хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Л.Буянбат: Хурал дотоод дэг, хурлаас баталсан дарааллын дагуу явагдаж, хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хурал хаасныг мэдэгдэв. Хурал 13.45 цагт дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТӨЛСӨН:

ТАНИЛЦСАН:  
ХУРЛЫН ДАРГА



Ш.МӨНХ-ОЧИР

Л.БУЯНБАТ